



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арван нэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/135/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн
Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж
Утас: 77721628
Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 47

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ХҮҮХДИЙН 11 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,002,209.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 958,257.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	179,197,261.04	110,499,143.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	96,348,441.84	32,381,328.86
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	96,348,441.84	32,381,328.86
3121	Төгрөг	96,348,441.84	32,381,328.86
31211	Төрийн сангийн харилцах	96,348,441.84	32,381,328.86
35	БАРАА МАТЕРИАЛ	82,848,819.20	78,117,815.10
351	Түүхий эд материал	910,000.00	910,000.00
35130	Эм боох материал	910,000.00	910,000.00
354	Хангамжийн материал	81,938,819.20	77,207,815.10
35410	Бичиг хэргийн материал	1,874,150.00	1,300,000.00
35420	Аж ахуйн материал	75,701,569.20	68,648,771.10
35450	Барилгын засварын материал	4,363,100.00	4,260,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	2,999,044.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,304,873,797.41	1,903,617,947.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,304,873,797.41	1,903,617,947.02
392	Биет хөрөнгө	1,287,160,464.07	1,885,977,947.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,373,655,878.50	1,981,621,667.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(147,177,415.44)	(171,706,984.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,325,680.50	87,435,480.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,570,319.15)	(60,852,450.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,704,621.30	77,591,489.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,822,821.36)	(35,650,512.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,865,325.00	11,865,325.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,970,485.28)	(4,707,017.88)
39217	Ном	150,000.00	380,950.00
393	Биет бус хөрөнгө	17,713,333.34	17,640,000.02
39301	Програм хангамж	2,857,500.00	2,857,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,454,166.66)	(2,527,499.98)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,310,000.00	17,310,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,484,071,058.45	2,014,117,090.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	9,368,270.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	9,368,270.00
413	Өглөг	-	9,368,270.00
4136	Бусад өглөг	-	9,368,270.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	9,368,270.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,484,071,058.45	2,004,748,820.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,484,071,058.45	2,004,748,820.98
512	Хуримтлагдсан үр дүн	1,410,337,811.31	1,931,015,573.84
51210	Өмнөх үеийн үр дүн	1,410,337,811.31	1,410,337,811.31
51220	Тайлант үеийн үр дүн	-	520,677,762.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,423,247.14	56,423,247.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,484,071,058.45	2,014,117,090.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	851,721,700.00	1,556,183,715.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,456,500.00	643,621,315.10
120	Нийтлэг татварын бус орлого	13,456,500.00	643,621,315.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	838,265,200.00	912,562,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	744,245,500.00	842,111,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,019,700.00	70,450,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,019,700.00	70,450,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	867,211,086.35	1,035,505,952.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	867,211,086.35	1,035,505,952.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	823,196,205.35	1,005,969,853.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	582,772,806.00	720,385,055.87
210101	Үндсэн цалин	426,376,645.00	473,910,839.00
210102	Нэмэгдэл	137,935,411.00	193,733,117.87
210104	Урамшуулал	18,460,750.00	34,318,139.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,756,090.23	83,754,782.11
210201	Тэтгэврийн даатгал	49,490,342.40	56,928,350.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,839,555.65	6,705,193.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,896,376.08	3,370,302.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2,705,922.85	3,353,947.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,823,893.25	13,396,990.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,442,919.00	45,218,701.00
210301	Гэрэл, цахилгаан	10,537,119.00	14,248,401.00
210302	Түлш, халаалт	16,131,600.00	11,818,500.00
210303	Цэвэр, бохир ус	17,774,200.00	19,151,800.00
2105	Нормативт зардал	51,347,134.20	63,178,895.00
210502	Хоол, хүнс	51,347,134.20	63,178,895.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	5,854,900.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	5,854,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	778,800.00	2,312,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	778,800.00	2,312,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,098,455.92	78,066,655.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,016,901.00	27,567,198.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,422,600.00	6,050,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,658,954.92	44,449,257.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,014,881.00	29,536,099.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,418,100.00	11,054,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,418,100.00	11,054,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	18,481,899.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,596,781.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,596,781.00	18,481,899.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(15,489,386.35)	520,677,762.53
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	862,408.16	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	862,408.16	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(862,408.16)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(16,351,794.51)	520,677,762.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	838,475,200.00	912,772,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,000.00	210,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	210,000.00	210,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	210,000.00	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	210,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	838,265,200.00	912,562,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	744,245,500.00	842,111,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,019,700.00	70,450,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,019,700.00	70,450,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	834,494,781.43	973,599,712.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	790,479,900.43	944,063,613.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	582,772,806.00	720,385,055.87
210101	Үндсэн цалин	426,376,645.00	473,910,839.00
210102	Нэмэгдэл	137,935,411.00	193,733,117.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	18,422,960.00
210104	Урамшуулал	18,460,750.00	34,318,139.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,756,090.23	83,754,782.11
210201	Тэтгэврийн даатгал	49,490,342.40	56,928,350.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,839,555.65	6,705,193.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,896,376.08	3,370,302.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2,705,922.85	3,353,947.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,823,893.25	13,396,990.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,442,919.00	45,218,701.00
210301	Гэрэл, цахилгаан	10,537,119.00	14,248,401.00
210302	Түлш, халаалт	16,131,600.00	11,818,500.00
210303	Цэвэр, бохир ус	17,774,200.00	19,151,800.00
2105	Нормативт зардал	51,347,134.20	63,178,895.00
210502	Хоол, хүнс	51,347,134.20	63,178,895.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,980,000.00	6,750,000.00
210604	Урсгал засвар	17,980,000.00	6,750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	778,800.00	2,312,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	778,800.00	2,312,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,402,151.00	22,463,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,748,201.00	16,421,780.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,653,950.00	6,042,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,014,881.00	29,536,099.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,418,100.00	11,054,200.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,596,781.00	18,481,899.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	5,734,949.00	3,139,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,734,949.00	3,139,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,734,949.00	3,139,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,734,949.00)	(3,139,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,754,530.43)	(63,967,112.98)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,102,972.27	96,348,441.84
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	96,348,441.84	32,381,328.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,433,748,121.23	1,433,748,121.23
Тайлант үеийн үр дүн	-	-	(34,083,261.30)	(34,083,261.30)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,310,000.00	56,423,247.14	1,410,337,811.31	1,484,071,058.45
Тайлант үеийн үр дүн	-	-	520,677,762.53	520,677,762.53
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,310,000.00	56,423,247.14	1,931,015,573.84	2,004,748,820.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Данс	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2	1,004,436,700.00	958,257,613.98	46,179,086.02	95.40
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	21	1,004,436,700.00	958,257,613.98	46,179,086.02	95.40
Бараа, үйлчилгээний зардал	210	993,382,500.00	947,203,413.98	46,179,086.02	95.35
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2101	732,052,500.00	720,385,055.87	11,667,444.13	98.41
Үндсэн цалин	210101	488,011,100.00	473,910,839.00	14,100,261.00	97.11
Нэмэгдэл	210102	219,242,700.00	193,733,117.87	25,509,582.13	88.36
Унаа, болон бусад нөхөн олговор	210103	-	18,422,960.00	(18,422,960.00)	
Урамшуулал	210104	24,798,700.00	34,318,139.00	(9,519,439.00)	138.39
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2102	90,709,300.00	83,754,782.11	6,954,517.89	92.33
Тэтгэврийн даатгал	210201	61,516,400.00	56,928,350.00	4,588,050.00	92.54
Тэтгэмжийн даатгал	210202	7,298,200.00	6,705,193.07	593,006.93	91.87
ҮОМШӨ ний даатгал	210203	3,649,100.00	3,370,302.04	278,797.96	92.36
Ажилгүйдлийн даатгал	210204	3,649,100.00	3,353,947.00	295,153.00	91.91
Эрүүл мэндийн даатгал	210205	14,596,500.00	13,396,990.00	1,199,510.00	91.78
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2103	63,700,600.00	45,218,701.00	18,481,899.00	70.99
Гэрэл цахилгаан	210301	16,999,100.00	14,248,401.00	2,750,699.00	83.82
Түлш, халаалт	210302	19,728,400.00	11,818,500.00	7,909,900.00	59.91
Цэвэр, бохир ус	210303	26,973,100.00	19,151,800.00	7,821,300.00	71.00
Нормативт зардал	2105	71,171,500.00	63,178,895.00	7,992,605.00	88.77
Хоол, хүнс	210502	71,171,500.00	63,178,895.00	7,992,605.00	88.77
Эд хогшил худалдан авах	2106	6,750,000.00	6,750,000.00	-	100.00
Урсгал засвар	210604	6,750,000.00	6,750,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2108	3,270,600.00	2,312,200.00	958,400.00	70.70
Мэдээллийн технологийн зардал	210806	3,270,600.00	2,312,200.00	958,400.00	70.70
Бараа үйлчилгээний бусад зардал	2201	25,728,000.00	25,603,780.00	124,220.00	99.52
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	19,685,800.00	19,561,580.00	124,220.00	99.37
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210902	6,042,200.00	6,042,200.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	213	11,054,200.00	11,054,200.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	2132	11,054,200.00	11,054,200.00	-	100.00

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арваннэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	213209	11,054,200.00	11,054,200.00	-	100.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2133	-	-	-	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	261090	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,004,436,700.00	894,290,501.00	110,146,199.00	89.03
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1310	842,902,400.00	842,111,800.00	790,600.00	99.91
Улсын төсвөөс санхүүжих	131001	842,902,400.00	842,111,800.00	790,600.00	99.91
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1320	70,450,600.00	51,968,701.00	18,481,899.00	73.77
Орон нутгийн төсвөөс	132001	70,450,600.00	51,968,701.00	18,481,899.00	73.77
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120004	91,083,700.00	210,000.00	90,873,700.00	0.23
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200042	210,000.00	210,000.00	-	100.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1200043	90,873,700.00	-	90,873,700.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4	96,348,441.84	96,348,441.84	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5	96,348,441.84	32,381,328.86	63,967,112.98	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	6	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	61	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	62	29	29	-	100.00
Удирдах ажилтан	620001	1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	620002	18	18	-	100.00
Үйлчлэх ажилтан	620003	10	10	-	100.00
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	63	160	160	-	100.00
Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	631	160	160	-	100.00
Төрийн өмчит СӨБ байгууллага	631001	160	160	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар аудитын явцад 1,080.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрсэн тул залруулга хийлгэлээ.

Энэ нь УИХ-ын гишүүний хандиваар өгсөн 180.0 төгрөгийн зах зээлийн үнэ бүхий 6 ширхэг агаар цэвэршүүлэгч нийт 1,080.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалаар бүртгэснийг үндсэн хөрөнгөөр бүртгэж залрууллаа.

Аудитаар залруулаагүй 5,339.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, 5,339.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өглөө.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 5,339.9 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 11,290.0 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.09.23-ны өдрийн Б/23 дугаар тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 1,114.9 мянган төгрөг суутган 10,034.8 мянган төгрөгийг 29 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 2,675.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бараа материалаар бүртгэсэн	1	1,080.0	1	1,080.0	1	1,080.0
Дүн	1	1,080.0	1	1,080.0	1	1,080.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0			1	2,664.0		
НДШ суутган буюу ногдуулаагүй.	1	2,675.9			1	2,675.9		
Дүн	2	5,339.9	-	-	2	5,339.9	-	-